

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн нэр	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:	2
1.3. Төслийн үндсэн үйл ажиллагаа:	2
1.4. Төслийн зорилго:.....	2
1.5. Төслийн хүчийн чадал:	2
1.6. Төслийн байршил.....	2
1.7. Төслийн барилга байгууламж, дэд бүтэц	3
1.8. Ус цэвэршүүлэх технологи, үндсэн үе шат.....	8
1.9. Төслийн техник, технологи.....	10
1.10. Төслийн хүрээнд ашиглагдаж байгаа болон импортлох химийн бодисууд, ашиглах хэмжээ	11
1.11. Хог хаягдал ба завсрын бүтээгдэхүүн.....	11
1.12. Ус хангамж, усны хэрэглээ.....	13
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
2.1. Гадаргын ус	14
2.2. Газрын доорх ус	14
2.3 Хөрсөн бүрхэвч	14
2.4 Ургамлан бүрхэвч	15
2.5. Амьтны аймаг	15
2.6. Тусгай хамгаалалттай газар нутаг	15
2.7. Нийгэм, Эдийн засаг	15
Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм	15
Хөдөлмөр эрхлэлтийн байдал	15
Ногоон байгууламж	16
Дэд бүтэц, үйлчилгээ	16
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ, ЗӨВЛӨМЖ	18
3.1. Төслөөс үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ	18
3.2. Төслөөс үзүүлэх гол сөрөг нөлөөллийн үнэлгээ	19
3.3. Нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл	20
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	21
4.1. БОМТ-ны төсөв	21
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	26
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	27

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Савхи, савхин бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжүүд	5
Хүснэгт 2. Үйлдвэрийн хаягдал усны бохирдлын төрлүүдээс хамааран ус цэвэрлэгээний аргуудыг сонгох нь	8
Хүснэгт 3. Арьс ширний үйлдвэрээс гарах хог хаягдал	11
Хүснэгт 4. Хөнгөн үйлдвэрийн усны норм	13
Хүснэгт 5. Усны хэрэглээний тооцоо	13
Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй асуудлууд	18
Хүснэгт 7. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн төрөл, нөлөөллийн зэрэг, үргэлжлэх хугацааны байгаль орчны үзүүлэлтүүдтэй харьцах нь	19
Хүснэгт 8. Төслийн гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	19
Хүснэгт 9. Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн төрөл	20
Хүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	22
Хүснэгт 11. 2024 онд тарих ногоон байгууламжийн төлөвлөгөө	24
Хүснэгт 12. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө	24
Хүснэгт 13. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө	25
Хүснэгт 14. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө	26
Хүснэгт 15. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт 16. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	27

Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн одоогийн фото зураг.....	3
Зураг 2. “Арилдий” ХХК-ийн арьс шир боловсруулах үйлдвэрийн байршлын зураг.....	3
Зураг 3. “Арилдий” ХХК-ийн төв барилга	4
Зураг 4. Барабан.....	4
Зураг 5. “Арь болосруулах үйлдвэрийн дэвтээлгийн үндсэн цех	4
Зураг 6. Арьс шир боловсруулах үйлдвэрийн одоогийн агуулах	4
Зураг 7. Арьс шир боловсруулах үйлдвэрийн түүхий эд материалын агуулах	5
Зураг 8. Арьс шир боловсруулах үйлдвэрийн дотор тал/ шинээр суурилуулсан тоног төхөөрөмжүүд/	6
Зураг 9. Үйлдвэрийн гаднах хаалга	7
Зураг 10. Ногоон байгууламж, зам талбай.....	8
Зураг 11. Бохир ус цэвэрлэх байгууламж	10
Зураг 12. Granofin © Easy F-90-ын энгийн хромгүй зөөлөн идээлэгтэй арьсан бүтээгдэхүүнүүд	11
Зураг 13. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч.....	14

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Арьс шир боловсруулах, савхи боловсруулах үйлдвэр” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Арилдий” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011070091	
3	Регистрийн дугаар	2068567	
4	Төслийн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар хот
		Сум/Дүүрэг	Баянгол дүүрэг, 20-р хороо
5	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
		Сум/Дүүрэг	Сонгинохайрахн
		Баг/Хороо	20-р хороо
		Гудамж/Байр	Үйлдвэрийн баруун бүс, ХД-ийн 64 тоот
		Утас	99118237
		Факс	-
		Гар утас	99118237
		Электрон шуудан	-
		Вэб хуудас	-
6	Захирлын хаяг	Нэр	Д.Арилдий
		Утас	-
		Факс	-
		Гар утас	99118237
		Электрон шуудан	arildii@outlook.com

1.3. Төслийн үндсэн үйл ажиллагаа:

“Арилдий” ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх, ноос ноолуур угаан БНХАУ, ТУРК болон ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС-ын зах зээлрүү нийлүүлдэг бөгөөд үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэн цаашид арьс ширийг эцсийн бүтээгдэхүүн /савхи, савхин бүтээгдэхүүн/ хүртэл боловсруулахаар төлөвлөж байна.

1.4. Төслийн зорилго:

Арьс ширний үйлдвэрийн байгаль орчинд ээлтэй химийн бодисыг импортлон оруулж ирэн өөрийн үйлдвэрлэлдээ ашиглан цаашид арьс ширийг эцсийн бүтээгдэхүүн /савхи, савхин бүтээгдэхүүн/ хүртэл боловсруулж Европ руу экспортлох.

1.5. Төслийн хүчийн чадал:

Тус арьс шир боловсруулах үйлдвэр нь хоногт 2 ээлжээр ажиллаж хоногт дундажаар үхрийн 1100 ширхэг арьс, хонь ямааны 4000 ширхэг арьс боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох хүчин чадалтай юм. Тус үйлдвэр нь жилийн туршид ажиллах бөгөөд улсын хэмжээгээр нийтээр тэмдэглэх баярын 11 өдөр, хөдөлмөрийн дотоод журмаар авч үзвэл жилд 251 өдөр ажиллаж нийт 1.100,000 ширхэг арьсыг боловсруулж экспортонд гаргахаар байна.

1.6. Төслийн байршил

“Арилдий” ХХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороонд орших өөрийн эзэмшлийн 17887 м2 талбайн хэмжээнд 1692 м2 бүхий үйлдвэрлэл үйлчилгээний ажлын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн одоогийн фото зураг



Зураг 2. “Арилдий” ХХК-ийн арьс шир боловсруулах үйлдвэрийн байршлын зураг

1.7. Төслийн барилга байгууламж, дэд бүтэц

Одоогийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч нь Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах 17887 м² талбайн хэмжээнд 1692 м² бүхий үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай, химийн материал хадгалах агуулах, граш, контор зэрэг дараах бүтээн байгуулалтыг хийгээд байна.

“Арилдий” ХХК нь үйлдвэрийн болон дэвтээлгийн үндсэн цехээс гадна оффисын байр, ажилчдын байр, түүхий эд ба бүтээгдэхүүний агуулах, химийн бодисын агуулах, ажилчдын цайны газар, халуун ус, цэвэрлэх байгууламж зэрэг хэсгүүдээс бүрдэнэ.



Зураг 3. "Арилдий" ХХК-ийн төв барилга



Зураг 4. Барабан



Зураг 5. "Арь болосруулах үйлдвэрийн дэвтээлгийн үндсэн цех
Арьс шир боловсруулах үйлдвэрт хэрэглэгддэг химийн материалуудыг үйлдвэрийн
байран дахь 100 м2 хэмжээтэй агуулахад хадгалдаг байна.



Зураг 6. Арьс шир боловсруулах үйлдвэрийн одоогийн агуулах



Зураг 7. Арьс шир боловсруулах үйлдвэрийн түүхий эд материалын агуулах

Тус арьс шир боловсруулах үйлдвэр нь хоногт 2 ээлжээр 8 цаг ажиллан, өдөрт дундажаар 6000-6500 ширхэг арьсанд анхан шатны боловсруулалт хийх хүчин чадалтай ба оргил ачааллын үе болох 9,10,11,12,1 болон 2-р саруудад өдөрт дундажаар хамгийн ихдээ 8000 ширхэг арьс шир боловсруулдаг байсан байна.

“Арилдий” ХХК нь үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэн цаашид арьс ширийг эцсийн бүтээгдэхүүн /савхи, савхин бүтээгдэхүүн/ хүртэл боловсруулахаар төлөвлөж дараах тоног төхөөрөмжүүдийг суурилуулан ашиглахад бэлэн болгосон байна.

Үүнд:

Хүснэгт 1. Савхи, савхин бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжүүд

Т/Т нэр	Хүчин чадал	тоо	Ү/улс
Арлах машин	15 квт	1 ширхэг	Чех улс
Турнер	15 квт	1 ширхэг	ХБНГУ
Каток	20 квт	1 ширхэг	ХБНГУ
Малиса	31 квт	1 ширхэг	БНХАУ
Вакуум	35.5 квт	1 ширхэг	БНХАУ
Хусах	35 квт	1 ширхэг	Чех улс
Нойтон арьс шахах	40 квт	1 ширхэг	БНХАУ
Нойтон арьс шахах	9 квт	1 ширхэг	Чех улс
Махлах	45 квт	1 ширхэг	БНХАУ
Талхианы барбан	2 квт	2 ширхэг	Монгол улс
Арьс чийглэгч	2 квт	1 ширхэг	Монгол Улс
Өнгөлөгч	9 квт	1 ширхэг	БНХАУ
Кела	13.5 квт	1 ширхэг	ХБНГУ
Зүлгүүр	15 квт	1 ширхэг	Италий улс
Тоос сорогч	5.5 квт	1 ширхэг	Италий улс
Будах камера	28 квт	1 ширхэг	БНХАУ
Сэв дарагч	8 квт	1 ширхэг	БНХАУ
Өнхөрдөг арлагч	8 квт	1 ширхэг	БНХАУ
Раман хатаалга	17 квт	1 ширхэг	БНХАУ
Дицлэх машин	1.5 квт	1 ширхэг	БНХАУ
Баллаар будагч	5 квт	1 ширхэг	БНСУ
Будгын бункер	4.5 квт	1 ширхэг	БНХАУ
Дүүжин хатаалга	2.2	1 ширхэг	БНХАУ





Зураг 8. Арьс шир боловсруулах үйлдвэрийн дотор тал/ шинээр суурилуулсан тоног төхөөрөмжүүд/

Зам, гадна талбайн тохижилт: “Арилдий” ХХК нь өөрийн ашиглалтын талбайд автомашинуы зогсоол, барилга байгууламж хоорондын явган хүний зам, хогийн сав, гэрэлтүүлэг зэргийг төлөвлөж тохижуулсан. Үүнээс гадна 50 гаран мод, бут сөөг тарьж хайс хашлагаар хамгаалан ургуулж байна.



Мод тарих байрлал



Зураг 9. Үйлдвэрийн гаднах хаалга



Зураг 10. Ногоон байгууламж, зам талбай

Цахилгаан хангамж: “Арилдий” ХХК нь цахилгааныхаа хэрэгцээг төвлөрсөн системээс авдаг.

Усны хангамж: Улаанбаатар хотын төвлөрсөн системт усан хангамжийн шугамд холбогдсон. Мөн “Арилдий” ХХК нь өөрийн зохих зөвшөөрлийн дагуу гаргасан 50 м-ийн гүний 10л/с ундрагатай худагтай байх ба шугам хоолой эвдэрсэн, ус тасарсан зэрэг нөхцлүүдэд ашигладаг байна.

Дулаан хангамж: Төвлөрсөн дулаан хангамжинд холбогдсон байна.

Бохир ус: “Арилдий” ХХК нь 2012 онд Фучир Холдинг ХХК-тай хамтран арьс шир боловсруулсан хаягдал усыг цэвэршүүлсэн саарал ус болгон дахин ашиглах зорилготойгоор хоногт 600 м3 ус цэвэрлэх хүчин чадалтай, бүрэн автомат бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтанд оруулан ашиглаж байна. Энэ байгууламж нь бүрэн автоматжсан бөгөөд 2-3 хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна.

1.8. Ус цэвэршүүлэх технологи, үндсэн үе шат

Арьс, шир боловсруулах үйлдвэрээс гарч байгаа бохир ус нь физик, хими, биологийн өөрчлөлтөд орсон ба бохирын зэрэглэлээр авч үзвэл “хүчтэй бохирдсон” ангилалд орж байгаа юм. Ерөнхийдөө бохир усыг цэвэрлэх арга нь механик цэвэрлэгээний, хими, физик-химийн, биологийн гэсэн хэсгээс бүрддэг. Бохир усан дахь нийтлэг хольцын төрлүүдийг ялгах, цэвэрлэх аргуудыг тодорхойлбол.

Хүснэгт 2. Үйлдвэрийн хаягдал усны бохирдлын төрлүүдээс хамааран ус цэвэрлэгээний аргуудыг сонгох нь

Хольцын төрлүүд	Цэвэрлэх аргууд
Том шнрх. хольц	Тороор шүүх
Янз бүрийн ширх. Х.	Нунтаглалт, гомогенжүүлэлт
Элс	Тунаах
Тос, өөх	Тосгүйжүүлэх
Дисперсэн ж. х	Коагуляци, флокуляци
Шүлт	Седментаци, флотаци, фильтраци, хүчлээр саармагжуулах
Хүчнл	Шүлтээр саармагжуулах
Хүнд металл	Тунадасжуулах эсвэл ион солилцолын
Сульфидууд	Тунадасжуулах, исэлдүүлэх
Хурдан нсэлддэг хольц	Илэлдүүлэх(идэвхжүүлсэн лагийн, биофильтрийн), анаэробын
Хэцүү исэлддэг хольц	Идэвхжүүлсэн лагийн адсорбци, ион солилцол
Азот	Нитрификацийн- денитрификацийн. ион солилцолын
Фосфор	Тунадасжуулах, ион солилцолын
Микроорганнзмууд	Хлороор болон бусад хүчтэй исэлдүүлэгчидээр нянгүйжүүлэх,

Механик цэвэрлэгээний арга: Шүүх, тунгаах ажлууд явагдаж хольцын овор хэмжээгээр том зүйлүүд зайлуулагдана.

Химийн цэвэрлэгээний арга: Энэ нь бохирдлыг үүсгэгч бодисын агууламж төрлөөс хамааран төрөл бүрийн урвалж хэрэглэх замаар цэвэршүүлнэ.

Физик-химийн олон төрлийн арга байх ба үүнээс заримыг доор дурьдвал.

- Сорбци
- ион солилцол
- эвапораци
- экстракцийн
- коагуляцийн
- флокуляци
- диализ
- Флотаци
- Нэрлэг, Ректификацийн арга
- Соронзон боловсруулалт

Биологийн арга: Биологийн цэвэрлэгээний аргын үндэс нь органик бодисоор хооллож амьдардаг олон тооны микроорганизмыг хэрэглэхэд оршино. Ингэхээр биологийн аргаар усан дахь органик бодисын бохирдлыг цэвэрлэхээс гадна органик биш бохирдлоос сульфидууд болон аммонийн давсыг цэвэрлэхэд энэ аргыг хэрэглэнэ.

Тайлбар:

1. Тортой худаг - энэ нь бохир усан дахь үс, махны үртэс хөвмөл томоохон зүйлсийг шүүж авах үүрэгтэй
2. Төвлөрсөн усан сан - шүүгдсэн усыг төвлөрүүлэх нэгдүгээр дамжага юм.
3. Элс тунгаах төхөөрөмж - элс, давс зэрэг томоохон ширхэгтэй бохирдуулагчийг цэвэрлэнэ.
4. Тунгаах төхөөрөмж - хаягдал усан дахь хөвөгч, цавуулаг зүйлсийг нэмэлт бодисын тусламжтайгаар тунгаана.
5. Даралтаар шүүх - Усанд агуулагдаж байгаа тослог болон бичил хөвмөл бодисыг даралттай хийгээр шахна. Үүний үр дүнд жижиг хэсгүүд нэгдэж усны дээд талд гарж ирэхэд цэвэрлэгч хавтангаар шүүж дараагаар сульфат төмрийг нэмэхэд усан дахь Ca^{2+} нь $CaCO_3$ болж тунадасжиж цэвэрлэгдэнэ.
6. Тохируулах цөөрөм - хаягдал усны хэмжээ болон чанарыг зохицуулах буюу тохиромжтой хэмжээнд хүртэл боловсруулалт хийнэ. Энэ шатанд усны pH байх ёстой хэмээндээ хүрнэ.
7. Усыг задлах төхөөрөмж - усан дахь задрахад төвөгтэй органик бодисыг задлах ба ингэснээр том молекулыг жижиг болгон биохимийн үйлчилгээг идэвхжүүлнэ.
8. 1,2 зэргийн хүчилтөрөгчжүүлэх цөөрөм - задарсан ор1дник бодис агуулсан хаягдал усаа хүчилтөрөгчөөр баяжуулан цэвэрлэх процессыг түргэсгэнэ.
9. Тунгаах цөөрөм - хүчилтөрөгчжүүлэх цөөрөмд боловсруулагдсан хаягдал усны үлдэгдэл жижиг хэсгүүдийг игүүнэ.
10. Дунд цөөрөм - энэ хаягдал усыг хадгалахын зэрэгцээ шүүх ажиллагааг гүйцэтгэнэ.
11. Кварцан шүүлт - үлдэгдэл бичил шавар хайрга, зэв цавуулаг арилгана.
12. Идэвхжүүлсэн нүүрсээр шүүх төхөөрөмж - хаягдал усан дахь ионууд, органик бодис болон үмхий үнэрийг арилгаснаар эдгээр үйл явц дуусна.
13. Цэвэр ус хадгалах сан - энд цэвэршүүлсэн ус хадгалагдах ба арьс, шир боловсруулах үйлдвэрлүү шилжүүлэх шугам хоолой, насос угсрагдсан байна.



Зураг 11. Бохир ус цэвэрлэх байгууламж

1.9. Төслийн техник, технологи

Манай улсад арьс ширний 30 гаруй үйлдвэр байдаг. Тэдгээр үйлдвэрүүд арьс, шир боловсруулахдаа хүрээлэн буй орчинд хорт хий болдог, гүний ус, газрын хөрсийг бохирдуулдаг бодис хэрэглэж, эцсийн бүтээгдэгдэхүүн гаргадаг. Тухайлбал, арьсыг хамгийн сайн идээлүүлдэг бодис хром юм байна. Гэвч энэ бодис нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэдгийг судлаачид тогтоожээ. Харин манай арьс ширний үйлдвэрүүд энэ аргыг өргөнөөр хэрэглэсээр байгаа юм.


Клариант фирмийн судлаачид Клаус Reineking,, нар арьс идээлэх талаар Granofin Легкая F-90 ба «EasyWhite Тан» буюу цагаан идээлгийн шинэ материал гаргаж авсан нь арьс идээлэх талаар хувьсгал хийсэн гэж дэлхий нийтээр тэмдэглээд байгаа юм. Цагаан идээлэгийн процесс нь уламжлалт хромын идээлэгтэй харьцуулахад үйлдвэрлэлийн процессыг идэвхижүүлэн хураангуйлах, идээлэгийн усны хэмжээг бууруулах зэрэг олон сайн үзүүлэлттэй байна.

Clariant-ын EasyWhiteTan систем нь арьс ширний үндсэн идээлэг. EasyWhiteTan систем гол үүргийг гүйцэтгэгч нь Granofin Easy F-90. Granofin Easy F-90-ээр идээлсэн хромгүй идээлэгтэй арьсыг хромоор идээлсэн арьстай харьцуулж үзэхэд ямарч ялгаагүй. Энэ идээлгийн арга нь маш хялбар байдаг. Granofin-ээр идээлсэн гутлын арьс нь энэ секторын хэрэгцээнд илүү тохиромжтой байна. Granofin Easy F-90 -ээр идээлсэн нойтон цагаан арьс нь хромоор идээлсэн нойтон цэнхэр арьстай адил нэмэлт идээлгийн, тослох, будгийн материалыг шингээн авч урвалд орох чадвар сайтай. Эдгээр материалууд нь арьсанд сайн шингэж холбогдох ба хаягдал усанд үлдэхгүй. Granofin Easy F-90 нь амфотер шинж чанартай ба хромгүй арьсыг нэмэлт идээлэг хийх, тослох, будах шинэ боломжийг

нээсэн үндсэн идээлгийн арга юм. Органик идээлгийн арга нь маш нягт, зөөлөн, атираагүй, бөх бат, нарийн ширхэгт гадаргуутай, ердийн чийглэг цагаан болгодог. Мөн будгийн хэрэглээг 20% хэмнэдэг. Арьсны өнгө нь тод гүн цэвэр өнгийг үзүүлдэг, дулаан даах чадварыг нь хангалтгүй гэж үзвэл хромоор дахин идээлж болно. Органик идээлэг нь усыг бага зарцуулдаг, металл, альдегид, фенол агуулаагүй, давс хэрэглээгүй, идээлгийн 2-3 үе шат / нэвтлэх, суурилаг өндөржүүлэх/ -уудыг хураангуйлсан хүрээлэн байгаа орчин, хаягдал усанд үзүүлж байгаа дарамтыг бууруулдаг.

Иймээс дэлхий даяар арьс ширийг хромоор идээлэхээс татгалзаж байгаа өнөө үед “Арилдий” ХХК нь техник технологио шинэчлэн органик цагаан идээлгээр арьс ширээ боловсруулахаар үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Төслийн судалгааны хүрээнд туршилт судалгаа хийсэн 5 хувилбараас экологийн ба эдийн засгийн хувьд тохиромжтой хувилбарыг сонгоход арьс боловсруулах процессуудыг хураангуйлах, усны зарцуулалтыг багасгах, химийн хэрэгцээт материалын нэр төрөл, хэмжээг бууруулах, биологийн задаргаа сайтай зэрэг үндсэн үзүүлэлтээрээ шаардлагад нийцсэн органик идээлэгч нь Granofin EASY F-90 идээлэгч байлаа.



Зураг 12. Granofin @ Easy F-90-ын энгийн хромогүй зөөлөн идээлэгтэй арьсан бүтээгдэхүүнүүд

1.10. Төслийн хүрээнд ашиглагдаж байгаа болон импортлох химийн бодисууд, ашиглах хэмжээ

“Арьс шир боловсруулах, савхи боловсруулах ҮЙЛДВЭР” төслийн хүрээнд “Арилдий” ХХК нь дараах 234 нэр төрлийн химийн бодис импортлон үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өрөгжүүлэх бүтээгдэхүүний чанарыг сайжруулах үүднээс нэмэлтээр 234 төрлийн химийн бодис импортлон ашиглахаар төлөвлөсөн байна.

Одоогоор нэг жилд 925600 кг буюу 925.6 тн химийн бодисыг импортлон ашиглаж байна.

1.11. Хог хаягдал ба завсрын бүтээгдэхүүн

Ямарваа нэгэн төсөл хэрэгжихэд тодорхой хэмжээний хог хаягдал үүсэх ба бий болох хаягдлын хэмжээ болон төрөл нь тухайн төслийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, хүчин чадлаас хамааран янз бүр байдаг.

Шингэн хаягдал. Ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг төвийн шугамаар зайлуулахаар төлөвлөж байна. Дээрх ахуйн хаягдлаас гадна ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт болон аюултай бодис тодорхой хэмжээгээр ялгарч түүнийг устгах шаардлага гарч болзошгүй. Энэ тохиолдолд Монгол Улсын Шадар сайд, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайд нарын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/136/215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ыг баримтална.

Хатуу хог хаягдал. Ус цэвэршүүлэх технологи ажиллагаанаас авч үзвэл цэвэршүүлэн гаргаж байгаа ус нь эргээд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бүрэн боломжтой байна. Ус цэвэршүүлэх явцад бохир лаг нэлээд хэмжээгээр гарах бөгөөд үүнийг умбуур бодисын хэмжээгээр зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэгдэнэ гэж тооцвол:

Зөвшөөрөх хэмжээ – 500 мг/л

Шинжилгээний утга – 5270 мг/л

Зөрүү утга – 4770 мг/л буюу 1л уснаас 4,77 гр умбуур бодис гарах ба үйлдвэрлэлийн ус хэрэглээний хэмжээгээр тооцож үзвэл 533739 кг хатуу хаягдал гарах ба үүн дээр арьс, шир боловсруулалтын явцад гарах хаягдал нэмэгдэнэ.

Хүснэгт 3. Арьс ширний үйлдвэрээс гарах хог хаягдал

№	Хатуу хаягдал	Хаягдлын хэмжээ, кг		
		Нэг арьснаас	Хоногт	Жилд
1	Үс, ноос	0,8	1200	301200
2	Год	0,15	225	56475

3	Халим	0,3	450	112950
4	Шийр /4 ширхэг/	1	1500	376500
5	Нийт	2,15	3375	847125

“Арилдий” ХХК нь тус төслийг хэрэгжүүлэхдээ хатуу хог хаягдал зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” Монгол улсын хуульд заасны дагуу “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-тэй “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулж шийдвэрлэсэн. Ахуйн хог хаягдлыг цуглуулж хураахгүйгээр өдөрт өдөртөө шууд ачуулдаг.

“Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-тэй “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулж шийдвэрлэсэн. Ахуйн хог хаягдлыг цуглуулж хураахгүйгээр өдөрт өдөртөө шууд ачуулдаг.

Дээрх ахуйн хаягдлаас гадна ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн бодис, түүний сав баглаа боодол тодорхой хэмжээгээр ялгарч түүнийг устгах шаардлага гарч болзошгүй. Энэ тохиолдолд Монгол Улсын Шадар сайд, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайд нарын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/136/215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын дагуу дараах үндсэн шаардлагууд тавигдана. Энэ талаар дэлгэрэнгүйг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлангийн 4.3.3.Химийн бодисын хаягдал түүний сав баглаа боодлыг устгах зөвлөмж хэсэгт тусгасан.

Хийн хаягдал. Ажилчдын хариуцлагагүй байдлаас болж аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөж улмаар химийн бодис агаар орчинд тоос, тоосонцор болон ууршин дэгдэх магадлалтай учраас бүх ажилчид аюулгүйн ажиллагааны дүрэм, зааврыг сайн биелүүлэх шаардлагатай. Мөн бүтээгдэхүүний сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж байх шаардлагатай.

1.12. Ус хангамж, усны хэрэглээ

Үйлдвэрийн усны хэрэглээг тооцохдоо БОНХАЖЯ-ны сайдын 2015.07.30-ний өдрийн А/301 тоот тушаалаар батлагдсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормоор тооцсон.

Хүснэгт 4. Хөнгөн үйлдвэрийн усны норм

Үйлдвэр	Бүтээгдэхүүний нэр, хэмжих нэгж	Нийт ус хэрэглээ м3	Үүнээс		
			Технологийн хэрэгцээнд м3	Ахуйн хэрэгцээнд м3	Техникийн хэрэгцээнд м3
Арьс боловсруулах үйлдвэр	- Тонн арьс	77.3	-	2	75.3

Усны хангамж: Улаанбаатар хотын төвлөрсөн системт усан хангамжийн шугамд холбогдсон. Мөн “Арилдий” ХХК нь өөрийн зохих зөвшөөрлийн дагуу гаргасан 50 м-ийн гүний 10л/с ундрагатай худагтай байх ба шугам хоолой эвдэрсэн, ус тасарсан зэрэг нөхцлүүдэд ашигладаг байна.

Бохир ус: “Арилдий” ХХК нь Арьс шир боловсруулсан хаягдал усыг цэвэршүүлсэн саарал ус болгон дахин ашиглах зорилготойгоор хоногт 600 м3 ус цэвэрлэх хүчин чадалтай, бүрэн автомат бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглаж байна.

Тус үйлдвэрт 76 хүн хоногт 2 ээлжээр ажиллаж хоногт дундажаар үхрийн шир 1100ш буюу 19,8тн Хонь, Ямааны 4000ш буюу 7,2тн арьс боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох хүчин чадалтай юм. Тус үйлдвэр нь жилийн туршид ажиллах бөгөөд улсын хэмжээгээр нийтээр тэмдэглэх баярын 11 өдөр, хөдөлмөрийн дотоод журмаар авч үзвэл жилд 251 өдөр ажиллана.

Хүснэгт 5. Усны хэрэглээний тооцоо

Ажиллах жил	Үхрийн шир	Үхрийн шир	Хонь, Ямааны арьс	Хонь, Ямааны арьс	Ажилчдын тоо	Ажиллах хоног - дундажаар	Усны норм	Хоногт	Жилийн усны хэрэглээ
Х.нэгж	ш	тн	ш	тн	хүн	хоног	тн	тн	тн
Ахуйн хэрэгцээнд	1100	19.8	4000	7.2	76	251	2	54	13554
Техникийн хэрэгцээнд							75.3	2033.1	510308.1
Нийт	27 тн								523862.1

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гадаргын ус

Төслийн талбайн төв цэгээс 2 км-ийн зайд Туул гол урсаж байна. Тус төсөл нь гадаргын усанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

2.2. Газрын доорх ус

Гидрогеологийн муж: Улирлын дунд тэжээлтэй муж Монголын төв хэсгийн дэд муж
Улаанбаатар хот орчмын гидрогеологийн ерөнхий нөхцөл: Улаанбаатарын газрын доорхи усны ай сав,уулс хоорондын артезийн ай сав бөгөөд Хойт Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг геологичид зураглан тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорхи усны тэжээлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал, зөөгдөл, хөлийн бүс болдог. Улаанбаатарын уулс хоорондын артезийн ай сав хэмжээнд палеозой, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна.

2.3 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь хөрсний ангилалаар тал газар, хөндий хотгорын хөрсний ангилалд хамаарна. Харин төрлийн хувьд ердийн хархүрэн ба сайргархаг хархүрэн хөрсний ангилалд хамаарна.

Төслийн талбай нь барилгажсан, талбайн хөрсөнд цементэн хатуу хучилт хийгдсэн, талбайн унаган төрх алдагдсан, талбайн ногоон байгууламжид асгамал хөрс тархсан байна.



Зураг 13. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

2.4 Ургамлан бүрхэвч

Улаанбаатар хот нь ургамал газар зүйн мужаар Евроазийн шилмүүст ойн мужийн Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт хамаарна. Улаанбаатар хот нь уулын ойт хээр, уулын тайга, уулын цөлийн хээр, хээрийн ба хуурай хээр, цөл, цөлийн хээр, өндөр уулын ургамалжилтын хэв шинжид хамаарна.

Төслийн талбай нь барилгажсан, талбайн хөрсөнд хатуу хучилт хийгдсэн байх бөгөөд нийт талбайн 5 орчим хувьд ногоон байгууламж байх бөгөөд тогтмол усалгаа арчилгаа хийгддэг.

2.5. Амьтны аймаг

Төслийн талбайн орчимд ажиглалтын явцад ямар нэгэн амьтны бүлгэмдэл илрээгүй. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.


2.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг үгүй болно. Хамгийн ойролцоо орших Улсын ТХГН нь Богдхан уул ДЦГ бөгөөд төслийн талбай хамгаалалтын бүсэд хамаарахгүй байна.


Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

2.7. Нийгэм, Эдийн засаг

Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хөдөлмөр эрхлэлтийн байдал



Баянгол дүүргийн хэмжээнд 18-64 насны 34,822 иргэн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 23 хувийг эзэлж байна. Энэ дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн бага буюу үндсэн дунджаас долоон хувиар бага (30%) байна. Энэ нь ялангуяа Баянгол дүүрэг нь Улаанбаатар хотын хүн амын 16 хувийг эзэлдэг, хүн амын тоогоор гуравдугаарт ордог дүүрэг гэдгийг тооцвол нэлээд ач холбогдолтой мэдээлэл гэж харагдаж байна. Баянгол дүүрэгт ажлын байр хангалтгүй байгаа нь бөөний болон жижиглэнгийн худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хотын түвшний дундаж 29%-тай харьцуулахад 44%) гэдэгтэй холбоотой байх магадлалтай юм. 6-р хороонд (0%) хамгийн бага буюу насанд хүрсэн 10,571 хүн хөдөлмөр эрхэлдэг; 22-р хороо (5%), 9-р хороо (7%) байна. Эдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны 20,111

байгаагаас 19,564 нь хөдөлмөр эрхэлж байгаа гэж мэдээлсэн байна. Харин эсрэгээрээ 13-р хороо (49%), 8-р хороо (46%), 1-р хороонд (43%) хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин хамгийн өндөр байна. Эдгээр гурван хороо нийлээд хөдөлмөрийн насны 18,252 иргэний 8,306 нь ажилгүй байна гэсэн мэдээлэл байна.


Ногоон байгууламж

Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар


(хэсгийн эзлэх хувь)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




	Өрхийн ногоон байгууламж	Хувийн хэвшлийн ногоон байгууламж	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж
Хороо #1	2.8	3.1	3.1
Хороо #2	2.2	2.3	2.3
Хороо #3	2.9	2.8	2.7
Хороо #4	2.9	2.6	2.7
Хороо #5	1.9	1.9	2.0
Хороо #6	2.6	2.5	2.6
Хороо #7	2.3	2.1	2.0
Хороо #8	2.9	3.0	2.8
Хороо #9	1.6	1.2	1.6
Хороо #10	3.0	2.9	2.7
Хороо #11	1.8	1.7	1.6
Хороо #12	2.3	2.4	2.5
Хороо #13	3.4	3.2	3.4
Хороо #14	3.6	3.6	3.8
Хороо #15	3.0	2.7	2.8
Хороо #16	2.3	2.4	2.1
Хороо #17	2.3	1.5	1.9
Хороо #18	2.5	2.4	2.5
Хороо #19	2.0	2.0	1.9
Хороо #20	2.5	2.8	2.3
Хороо #21	2.2	1.8	1.8
Хороо #22	2.5	2.0	1.9
Хороо #23	2.7	2.4	2.6
Хороо #24	2.4	2.0	2.0
Хороо #25	2.3	2.1	2.1


Дэд бүтэц, үйлчилгээ

ХҮНСНИЙ БҮС ЗҮЙЛС

Хүнсний бүс бүтээгдэхүүн хэрэглээний хүмүүс (саягайн эзлэх хувь)




Хүнсний бүс бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (саягайн эзлэх хувь)




ИНТЕРНЭТ

Интернетэд холбогддоггүй хүмүүс (саягайн эзлэх хувь)




Интернетийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (саягайн эзлэх хувь)




ЭРҮҮЛ МЭНД

Эрүүд мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (саягайн эзлэх хувь)




Эрүүд мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (саягайн эзлэх хувь)




УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (саягайн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (саягайн эзлэх хувь)



ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ, ЗӨВЛӨМЖ

3.1. Төслөөс үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

“АРИЛДИЙ” ХХК-ийн хэрэгжүүлэх “АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ, САВХИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нөлөөлөлд өртөж болзошгүй бусад хүчин зүйлс байгаа эсэхийг нарийвчлан авч үзэх асуудлуудыг төсөл хэрэгжих газрын байршил, үйл ажиллагаатай холбогдуулан дараах байдлаар тодорхойллоо.

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй асуудлууд

№	Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход анхаарах асуудлууд	Хариулт
1	Төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх	Тийм
2	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй ус намгархаг газар, онцгой тогтоцтой уулс, ой мод зэрэг экологийн чухал ач холбогдол бүхий эмзэг газар байгаа эсэх	Үгүй
3	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх	Тийм
4	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Тийм
5	Төсөл хэрэгжих үед хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд нөлөөлөхүйц осол аваар, эрсдэл гарч болзошгүй эсэх	Тийм
6	Өмнө нь ямар нэгэн төсөл хэрэгжиж байгаагүй зэлүүд газарт хэрэгжих эсэх	Үгүй
7	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Үгүй
8	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд амралт зугаалга болон олон нийтийн газар, барилга байгууламж байгаа эсэх	Үгүй
9	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй суурин газар байгаа эсэх	Тийм
10	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд эмнэлэг, сургууль, шашны мөргөлийн газар байгаа эсэх	Үгүй
11	Тухайн төслийг хэрэгжүүлэхээс өмнө хүний үйл ажиллагааны улмаас бохирдол доройтолд орсон өөрөөр хэлбэл байгаль орчны стандартын үзүүлэлтээс хэтэрсэн бохирдол үүссэн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутаг байгаа эсэх	Тийм
12	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь газар хөдлөл, хөрсний гулсалт, үер, манан будан, хүчтэй салхи шуурга зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий эсэх	Үгүй
13	Төсөл хэрэгжүүлэх үед хог хаягдал гарах эсэх	Тийм
14	Агаар орчинд тоос тархах эсэх	Тийм

Хүснэгт 7. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн төрөл, нөлөөллийн зэрэг, үргэлжлэх хугацааны байгаль орчны үзүүлэлтүүдтэй харьцах нь

Нөлөөлөлийн шинж чанар	Нөлөөллийн төрөл				Нөлөөллийн зэрэг					Нөлөөллийн үргэлжлэх хугацаа				
	Эерэг	Сөрөг	Шууд бус	Шууд	Нөлөөгүй	Маш бага	Бага	Дунд	Их	Түр зуурын	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Байнгын
1. Байгаль орчны өөрчлөлт														
Агаарын бохирдол		+		+		+							+	
Усан орчны өөрчлөлт														
Хөрсний элэгдэл эвдрэл														
Ургамлан нөмрөгийн өөрчлөлт														
Амьтны аймгийн өөрчлөлт														
2. Бусад нөлөөлөл														
Химийн хортой, аюултай бодисын ууршилт явагдснаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх		+	+			+						+		
Химийн бодис хадгалах горим зөрчигдснөөс эрсдэл учирах		+	+			+						+		
Хог хаягдал		+	+			+							+	
Дуу чимээний нөлөөлөл		+	+		+					+				
Дүн	-	2	4	1	1	4	-	-	-	1	2	2	-	-
Тайлбар: Болзошгүй сөрөг нөлөөлөлд Хөрсний элэгдэл эвдрэл, Ургамлан нөмрөгийн өөрчлөлт, Амьтны аймгийн өөрчлөлт, Усан орчны өөрчлөлт зэрэг нь болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөхгүй ба үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа болон химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт зэргээс үйлдвэрийн технологийн горим алдагдах, анхаарал болгоомжгүй байдлаас химийн бодис асгарах, алдах зэрэг нь төслийн зүгээс агаар орчинд болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлж болохоор байна.														

Тоос, дуу чимээ, хийн бохирдол нь байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй байгаа бөгөөд үүнээс шууд бус нөлөөлөл 80%, шууд нөлөөлөл 20% - тай байна.

Хүснэгт 26. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн зэрэг, үргэлжлэх хугацаа, %

Нөлөөллийн зэрэг, %	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа, %
Нөлөөгүй	Түр зуурын
Маш бага	Богино хугацааны
Бага	Дунд хугацааны
Дунд	Урт хугацааны
Их	Байнгын

Төслөөс байгаль орчинд учруулах болзошгүй сөрөг нөлөөлөл нь шууд бус буюу маш бага зэрэгтэй, богино ба дунд хугацаанд үргэлжлэнэ гэж дүгнэж байна

3.2. Төслөөс үзүүлэх гол сөрөг нөлөөллийн үнэлгээ

“АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ, САВХИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсоны үндсэн дээр төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

“АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ, САВХИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг нэгтгэн түүний эрчим, үргэлжлэх хугацааг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 8. Төслийн гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Ажиллагсад бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгарах алдагдах тохиолдолд амьсгал, арьс, нүдэнд хүрэлцэж	Агуулахын ажилчид, эргэн тойрны хүн ам,	Шууд-Их	Төсөл хэрэгжих хугацаанд

	цочроох, улайх, үрэвсүүлж болзошгүй.			
2	Хадгалалтын горим алдагдсанаас галын аюул үүсвэл шаталтын үр дүнд хорт хий ялгаруулж байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.	Агуулахын ажилчид, эргэн тойрны хүн ам, экосистем	Шууд-Дунд	
3	Гадаад болон дотоод орчны агаар химийн бодисын тоосонцроор бохирдох		Шууд-Дунд	
4	Химийн бодисын сав баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг журмын дагуу зайлуулж ил задгай хаях зэргээс байгаль орчныг бохирдуулж болзошгүй.		Шууд-Дунд	

Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тайлангийн химийн бодисын эрсдлийн үнэлгээ, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тус тус тодорхой дэлгэрэнгүй оруулсан.

3.3. Нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл

Хүн ам ихээр суурьшсан Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд хэрэгжиж буй уг төсөл нь цаашдын нийгэм-эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлхээр байна.

Хүснэгт 9. Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн төрөл

Нөлөөллийн шинж чанар Үзүүлэлтүүд	Нөлөөллийн төрөл			
	Эерэг	Сөрөг	Шууд бус	Шууд
Ажлын байр нэмэгдэх	+			+
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+			+
Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих	+			+
Ядуурлыг бууруулах	+			+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	+			+

Төслөөс нийгэм эдийн засагт эерэг шууд нөлөөлөл (100%) байгаа бол сөрөг шууд бус нөлөөлөл байхгүй байна. Үүнээс эерэг, шууд нөлөөлөл нь 100%-тай байна. Иймд уг төсөл нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзлээ.

Эерэг нөлөө:

- Улаанбаатар хотын иргэд ажлын байраар хангагдахаас гадна улс, орон нутагт татвар, төлбөр хэлбэрээр төсвийн бүрдүүлэлтэнд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах юм.
- Үйлдвэрлэл, үйлчилгээ үйлдвэрийн салбар хөгжиж улс, иргэнд орох орлого нэмэгдэх сайн талтай.
 - Хүн ард эрүүл мэнд үйлчилгээг чанарын өндөр түвшинд авах.
- Үндэсний үйлдвэрлэлд хувь нэмэр оруулан зах зээлд бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах

Сөрөг нөлөө:

Эдийн засгийн салбарт тус төслөөс сөрөг нөлөөлөл байхгүй бөгөөд нийгмийн салбарт бага хэмжээгээр сөрөг үзэгдэл үүсч болзошгүй юм.

Үүнд:

- Үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж аваар, химийн бодис болон түүхий эдийн ууршилт, хийн хог хаягдал орчныг бохирдуулснаар оршин суугчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх,

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан гол сөрөг нөлөө болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад чиглэгдсэн байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж төслөөс үүдэн гарах байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, хамгаалахад гол зорилго нь оршино.

4.1. БОМТ-ны төсөв

№	Зардлын ангилал	2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	Дотоод зардал+400.000
2	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн зардал	500.000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах зардал	-
4	Хог хаягдлын менежментийн зардал	4,000.000
5	ОХШХ-ын зардал	1,430.000
6	Удирдлага зохион байгуулалт	1,100.000
7	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь	-
Нийт зардал		7,430.000

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 10. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар	Машин техникийн шатахуун, тос тосолгоо, шингэний асгаралтын хяналтыг хийх	Х/Б-и Агуулах орчим, Зогсоолын талбай	-				Дотоод зардал	MNS 6808:2019 Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага
	Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавьж, бактер үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийж байх	Хогийн цэг	Засвар үйлчилгээ	-	Хуваарийн дагуу	-	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
Хөрсөн бүрхэвч	Явган хүний зам, машины зогсоолыг тогтмол сайжруулж байх, хатуу хог хаягдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхгүй байх	Төслийн талбайд					Дотоод зардал	MNS3297-1991, "Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм"
	Шатах тослох материал болон Химийн бодис бүхий бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд ашиглах асгаралтын иж бүрдэл байршуулах	Төслийн талбайд	2ш	200,000	400,000		2024 он	MNS ISO 22320:2020

Ургамлан нөмрөг	Орчныг зүлэгжүүлэх	Төслийн талбайд	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасана.		2024 он	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулж, байнгын бэлэн байдалд байлгах,	Галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, санамж, зурагт хуудас бэлтгэж байрлуулах	Ажилчдын байр дотор	ХАБ-ын зардал		2024 он	Гамшгаас хамгаалах хууль
Ажлын байранд нарийн дэг журам тогтоож, тамхи татах тусгай байр, галтай ажил, хийн ба цахилгаан гагнуурын ажлыг аюулгүйн нөхцлийн дагуу боловсруулсан журмын дагуу хийж,	Ил задгай гал гаргахгүй байх зарчмыг баримтлан зохион байгуулж ажиллуулах,	Төслийн талбай	Дотоод зардал		2024 он	Барилгын норм дүрэм, хөдөлмөрийн тухай хууль, аюулгүйажиллагааны дүрэм, журам, галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт			400.000			

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Салхины хаалт хамгаалалтанд хашаалж ургадаг мод тарих боломж, туршилтыг судалж нэвтрүүлэх хэрэгтэй. Оффис, ажлын байрны орчимд цэцгийн мандал байгуулах. Орчны тохижилтын ерөнхий төлөвлөгөө болон байгаль хамгаалах төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтөд заасан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Хүснэгт 11. 2024 онд тарих ногоон байгууламжийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайд мод, бут тарих тарималжуулах	Шар хуайс	Хашааны дагуу -хуайс	ш	50	5.000	250,000 + Арчилгаа	2024 он	MNS 5918:2008; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж
	Хайлаас тарьж ургуулах	Төслийн талбай дотор хайлаас	ш	50	5.000	250,000 + Арчилгаа	2024 он	МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
Нийт					500.000			

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2024 он			Үйл ажиллагааны явцад	Тухайн үед нь шийдвэрлэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид 2024 оны БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэглээний норм, гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 13. Төслийн хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, дахин ашиглах боломжтой зүйлс (цаас, шил, хуванцар сав, ашигласан тос, хаягдал дугуй г.м)-ийг шаардлагатай газруудад нийлүүлэх;	Хог хаягдлын ангилан ялгалтын сав нэмэгдүүлэх, Сургалт орох, Хэрэглээнд хяналт тавих	Үйлдвэр, Агуулах, Оффис орчим	ш	4.000.000	1	4.000.000	2024 он	MNS3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
Нийт				4,000.000				

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь тус төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Бид 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон давтамжийг тусгалаа.

Хүснэгт 14. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төгрөг ₮	Төрөл	Баримтлах стандарт, арга, аргачлал
АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ							
Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	Оффис орчим	Улирал бүр	4	20,000.00	80.000	-	MNS 4585:2016 Монгол улсын агаарын чанарын стандарт
	Агуулах	Улирал бүр	4	20,000.00	80.000		
Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Агуулах	Улирал бүр	4	80,000.00	320.000	NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, VOCs-BTEX) CO ₂	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008/
	Үйлдвэр	Улирал бүр	4	80,000.00	320.000		
УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ							
ГДУ геохимийн судалгаа: Макро, микро элемент	Гал тогоо	Улирал бүр	4	70,000.00	210.000	HCO ₃ , SO ₄ , CL, Na, K, Mg, Ca бусад	MNS 0900:2018
Усны эрүүл ахуйн үзүүлэлт,	Гал тогоо	Улиралд	4	25,000.00	100.000	Нянгийн шинжилгээ	MNS 0900:2018
ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ							
Хөрсний чанар – Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд,	Ногоон байгууламж	Жилд	2 удаа	80,000.00	160.000	Шимт хөрсний овоолгуудын үржил шимийн үзүүлэлт	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
Хөрсний чанар – Хүнд металлын шинжилгээ	Зогсоол орчим	Жилд	2 удаа	80,000.00	160.000	Хөрсөн дэх хүнд металлын бохирдол тодорхойлох	
Нийт				1,430.000			

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 15. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2024 он				
		Сар	Сар	Сар		
Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг батлагдсан журмын дагуу жил бүр боловсруулан БОАЖЯамаар батлуулах;	Дотоод зардал	2024 он			Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлын менежментийн талаар жилд 1 удаа сургалт зохион байгуулах	1,000.000	2024 он			Захирал	Хог хаягдлын тухай хууль
Байгаль орчны идэвхтнийг сонгон урамшуулах	100.000	2024 он			Захирал	-

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 16. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
БОМТ-ыг таниулах, мэдээлэх, таниулах хорооны ИНХ	Цаасан хэлбэрээр, Танилцуулга	Төлөвлөгөөт Ажлын тайлан, Биелэлтийн үр дүн, Дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 дугаар сард	Дотоод зардал	Төсөл хэрэгжүүлэгч
БОАЖЯам	Тайлан	БОМТ-ний биелэлтийн тайлан	11-р сарын 1 ний дотор	Дотоод зардал	Төсөл хэрэгжүүлэгч
Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Тайлангаар танилцуулж бичгээр санал авна	Дараа жилийн БОМТ-г батлуулах	12-р сарын 30 ны дотор	Дотоод зардал	Төсөл хэрэгжүүлэгч